



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН  
ГАЗАР**





# **Хүний амын төрөлт, нас баралт, өвчлөлийн МЭДЭЭЛЭЛ**

**2024 оны 6 дугаар сарын байдлаар**

**Мөрөн сум**

## ТӨРӨЛТ

Аймгийн хэмжээнд 2024 оны эхний 6 сарын байдлаар 983 эх амаржсан нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 135 тохиолдол буюу 12,1%-иар буурсан байна. Төрөлт Бүрэнтогтох, Жаргалант, Рэнчинлхүмбэ, Түнэл, Улаан-Уул, Цагаан-Уул, Цэцэрлэг, Хатгал сумдад өсч, бусад сумдад өмнөх оны мөн үеэс буурсан үзүүлэлттэй байна. Нийт төрсөн эхчүүдээс 6 ба түүнээс дээш удаа хяналтад хамрагдсан хамрагдалтын хувь 65,2% байна.



## ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНД


Аймгийн хэмжээнд 2024 оны эхний 6 сарын байдлаар нийт 984 хүүхэд амьд төрсөн нь өнгөрсөн оны мөн үеэс 137 тохиолдолоор буурсан байна. Амьд төрсөн хүүхдийн 3.9 хувь /38/ нь бага жинтэй буюу 2500 гр-аас доош жинтэй төрсөн байна. Төрөөд нэг цагийн дотор хөхөө амласан хүүхдийн хувь 98,3 хувь байна. 5 хүртэлх насны хүүхдийн өсөлт хөгжлийн хяналтанд 2024 оны эхний 6 сард нийт 30595 хүүхэд жинлэж, жинлэсэн хүүхдийн 0,03 хувь нь туранхай, 0,1 хувь нь тураалтай, 0,1 хувь нь өсөлтийн хоцрогдолтой байна. 55.9 хувь нь Д амин дэм, 7.3 хувь нь олон найрлагат бичил тэжээл, А амин дэмийг 10180 хүүхэд хэрэглэсэн байна.

## НЯЛХАСЫН ЭНДЭГДЭЛ

Аймгийн хэмжээнд 2024 оны эхний 6 сарын байдлаар нялхсын эндэгдлийн 16 тохиолдол бүртгэгдсэн нь 2023 оны мөн үеэс 6 тохиолдлоор өсч, 1000 амьд төрөлтөнд 16.3

ногдож байна. Нийт 13 тохиолдол буюу 81.3 хувь нь эмнэлэгт эндсэн бөгөөд эндсэн хүүхдийн 6 нь эмэгтэй хүүхэд байна.


Нялхсын эндэгдлийг шалтгаанаар нь авч үзвэл:




### 1-5 НАС ХҮРТЭЛХ ХҮҮХДИЙН ЭНДЭГДЭЛ

2024 оны эхний 6 сарын байдлаар 1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 6 тохиолдол бүртгэгдсэн ба өнгөрсөн оны мөн үетэй адил тохиолдол бүртгэгдсэн байна. 1000 амьд төрөлтөнд 6,1 ногдож байна. Хүүхдийн эндэгдлийг оношоор нь авч үзвэл амьсгалын тогтолцооны эмгэг 3, осол гэмтлийн шалтгаант нас баралтын 3 тохиолдол тус тус бүртгэгдсэн байна.

5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл,  
2024 оны эхний 6 сар бодит тоогоор



5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн шалтгаан,  
2024 оны эхний 6 сарын байдлаар




## НАС БАРАЛТЫН ҮЗҮҮЛЭЛТ

2024 оны эхний 6 сарын байдлаар 385 тохиолдол бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 23 тохиолдлоор өссөн байна. Нийт нас баралтын 17,1 хувь нь эмнэлэгт нас барсан ба үүнээс 37,9 хувь нь хоног болоогүй нас баралт байна. Осол гэмтлийн нас баралт 60 тохиолдол бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 17 тохиолдлоор өссөн, нийт нас баралтын 15,6 хувийг эзэлж, 10000 хүн амд 4,4 ногдож байна. Хорт хавдрын нас баралт 118 тохиолдол бүртгэгдсэн ба өнгөрсөн оны мөн үеэс 9 тохиолдлоор өсч, нийт нас баралтын 30,6 хувийг эзэлж, 10000 хүн амд 8,6 ногдож байна.


Нийт нас баралтын тэргүүлэх шалтгаан: /10000 хүн амд/

1. Цусны эргэлтийн тогтолцооны өвчин- 11.1
2. Хавдар-8.6
3. Гадны шалтгаант өвчлөл- 4.4
4. Амьсгалын тогтолцооны өвчин-1.2
5. Хоол боловсруулах тогтолцооны эмгэг-0.5

Нас баралтын мэдээлэл,  
2024 оны эхний 6 сарын байдлаар



Осол гэмтлийн шалтгаант нас баралт,  
2024 оны эхний 6 сарын байдлаар




Аймгийн хэмжээнд 2024 оны эхний 6 сарын байдлаар нийт эдийн шинжилгээ 1588, эсийн шинжилгээ 3384 хийгдсэн байна. Аймгийн Нэгдсэн эмнэлэгт нийт 47 нас баралт буюу 42.6% эмгэг судлалын задлан шинжилгээ хийгдэж үндсэн оношийн зөрүү 4 тохиолдол бүртгэгдсэн байна. Задлан шинжилгээ хийгдээгүй нас баралт 23 тохиолдол байна.


### АМБУЛАТОРИ СТАЦИОНАРИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТ

Аймгийн хэмжээнд 2024 оны эхний 6 сарын байдлаар амбулаторид нийт 367026 үзлэг хийгдсэнээс 46.1 хувийг урьдчилан сэргийлэх үзлэг, 39.0 хувийг өвчний учир амбулаторид, 5.2 хувийг идэвхитэй хяналтын үзлэг, 7.4 хувийг гэрийн идэвхитэй үзлэг, 2.2 хувийг гэрийн дуудлагын үзлэг эзэлж байна.

Амбулаторийн үзлэгийн төрөл




### Амбулаторийн үзлэг, 2023-2024 оны эхний 6 сарын байдлаар



### ЖИРЭМСЭНИЙ ХЯНАЛТ

Шинээр хяналтанд авсан нийт 855 жирэмсэн эмэгтэйчүүдээс 91,5 хувь нь жирэмсний эрт үедээ хяналтанд хамрагдсан байна. Цусны шинжилгээнд 93.7 хувь нь хамрагдаж, 1.4 хувь нь цус багатай гарсан байна. Эхний 6 сарын байдлаар жирэмсний хяналтанд шинээр орсон эхчүүдээс трихомониаз, заг хүйтэн илрүүлэх шинжилгээнд 92.6 хувийг, тэмбүү илрүүлэх шинжилгээнд 96.4 хувийг, ХДХВ илрүүлэх шинжилгээнд 96.0 хувийг тус тус хамруулж заг хүйтэн-8 трихомониаз-6, тэмбүү-17 тохиолдлыг тус тус бүртгэн эмчилсэн байна.

### Жирэмсэний эрт хяналтын хувь, 2024 оны эхний 6 сарын байдлаар



### ХАЛДВАРТ БУС ӨВЧИН

2024 оны эхний 5 сарын байдлаар халдварт бус өвчлөл 42212 тохиолдол бүртгэгдсэн ба өнгөрсөн оны мөн үеэс 35209 тохиолдлоор буурсан байна. 10000 хүн амд 3071.6 байгаа ба осол гэмтлийн өвчлөл 539 бүртгэгдэж, нийт халдварт бус өвчний 1.3 хувийг эзэлж, 10000 хүн амд 39.4 байна.

Амбулаторийн өвчлөлийн тэргүүлэх шалтгаан: /10000 хүн амд/

1. Хоол боловсруулах эрхтэн тогтолцооны өвчин- 831.6
2. Цусны эргэлтийн тогтолцооны өвчин- 988.0
3. Амьсгалын эрхтэн тогтолцооны өвчин-627.7
4. Шээс бэлгэсийн тогтолцооны эмгэг-311.8
5. Нүд ба түүний дайврын өвчин-300.3



Стационарт нийт 16086 хүн хэвтэж эмчлүүлж, 107899 ор хоног ашигласан ба дундаж ор хоног 6.7, орны эргэлт 18.3, орны фонд ашиглалт 122.6 фонд ашиглалтын хувь 74.3 байна.

Аймгийн хэмжээнд 2024 оны эхний 6 сарын байдлаар нийт 10428 түргэн тусламжийн дуудлага хүлээж авч гүйцэтгэсэнээс 14.1 хувь /1470/ нь алсын дуудлага, 2.0 хувь /213/ нь осол гэмтлийн дуудлага байна. 1 өдөрт дунджаар аймгийн хэмжээнд 57.9 дуудлага, АНЭ 16.9 дуудлага тус тус хүлээн авч гүйцэтгэжээ.


## ХАЛДВАРТ БУС ӨВЧНИЙ ЭРТ ИЛРҮҮЛЭГ ҮЗЛЭГИЙН МЭДЭЭЛЭЛ

2024 оны эхний 6 сарын байдлаар артерийн гипертензи эрт илрүүлгийн үзлэгт нийт 27448 хүн анх хамрагдаж, хамрагдвал зохих хүн амын 31.5 хувийг эзэлж байна. Нийт үзлэгт хамрагдсан хүний 42.6% эрэгтэй, 57.4% нь эмэгтэй байна.


Давтан үзлэгт 632 хүн хамрагдсан ба үүнээс оношлогдсон артерийн гипертензи 137 буюу 21.7% нь онош баталгаажсан байна. Чихрийн шижин өвчний эрт илрүүлгийн үзлэгт нийт 21212 хүн анх хамрагдаж, хамрагдвал зохих хүн амын 39.4 хувийг эзэлж байна. Нийт үзлэгт хамрагдсан хүний 41.8% эрэгтэй, 58.2% нь эмэгтэй байна. Давтан үзлэгт 87 хүн хамрагдсан ба үүнээс оношлогдсон 7 буюу 8.0% нь онош баталгаажсан байна.



Эрт илрүүлэг үзлэгийн хувь, нэгжээр



Эрт илрүүлэг үзлэгийн хувь, нэгжээр



## ӨРХИЙН ЭМТ-ИЙН ҮЗҮҮЛЭЛТ

Өрхийн ЭМТ нийт үзлэг 105343 байгаа ба үзлэгийн төрлөөр нь авч үзвэл:

- Урьдчилан сэргийлэх үзлэг 65.2 хувь
- Өвчний учир үзлэг 11.3 хувь
- Диспансерийн хяналт 5.9 хувь
- Гэрийн идэвхитэй эргэлт 17.2 хувь
- Гэрийн дуудлага 0.4 хувийг тус тус эзэлж байна.

Халдварт бус өвчний 2014 тохиолдол бүртгэгдэж, 5 хүртэлх насны хүүхдийн амьсгалын замын цочмог өвчин 9.2 хувийг, 5 хүртэлх насны хүүхдийн халварт бус суулгалт 0.2 хувийг тус тус эзэлж байна.

Шинээр хяналтанд авсан 303 жирэмсэн эмэгтэйдгээс 87,1 хувийг эрт үед нь хяналтанд авч 93,1 хувийг цусны шинжилгээнд хамруулсан байна.

Нийт 122 нас баралт бүртгэгдсэн ба Аймгийн Нэгдсэн Эмнэлэгт 26 тохиолдол байна. Хорт хавдрын нас баралт 48, 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 5 тохиолдол бүртгэгдсэнээс аймгийн нэгдсэн эмнэлэгт 4 тохиолдол эндсэн байна.

## ХУВИЙН ЭМНЭЛГИЙН ҮЗҮҮЛЭЛТ



Хувийн эмнэлгүүд нийт 19614 үзлэг хийснээс

- Урьдчилан сэргийлэх үзлэг 12.5 хувь
- Диспансерийн хяналт 3.0 хувь
- Гэрийн идэвхитэй эргэлт 0.01 хувь
- Гэрийн дуудлагаар 0.01 хувь
- Өвчний учир үзлэг 84.5 хувийг тус тус эзэлж байна.

Стационариар нийт 4752 хүн хэвтэн эмчлэгдэж, 34126 ор хоног ашигласан ба дундаж ор хоног 7.2 орны эргэлт 17.0 ба орны фонд ашиглалт 121.9, орны фонд ашиглалтын хувь 73.9 байна.

Нийт халдварт бус өвчний 455 тохиолдлоос 5 хүртэлх насны хүүхдийн амьсгалын замын цочмог өвчин 429 тохиолдол бүртгэгдсэн байна.

## **ХАЛДВАРТ ӨВЧИН**

Аймгийн хэмжээнд эхний 6 сарын байдлаар 740 халдварт өвчний тохиолдол бүртгэгдэж 10000 хүн амд 53.8 ногдож байна. 2023 оны мөн үед 744 тохиолдол, 10000 хүн амд 54.0 ногдож байжээ. 10000 хүн амд ногдох халдварт өвчний гаралт Тосонцэнгэл /78.9/, Цэцэрлэг /76.3/, Чандмань-Өндөр /85.5/, Эрдэнэбулган /57.8/, Мөрөн /95.4/ суманд аймгийн дунджаас тус тус өндөр байна.


Нийт халдварт өвчнөөс БЗХӨ 40.7 хувь, сүрьеэ 2,7 хувь, амьсгалын замын өвчин 51.2 хувь, гэдэсний халдварт өвчин 4.2 хувь, зоонозын болон мал амьтнаас хүнд халдварладаг өвчин 0,7 хувь, цусан халдвар 0,1 хувь, арьс салтстаар халдварлах халдвар 0,4 хувийг тус тус эзэлж байна.

## **ЦОЧМОГ ХАЛДВАРТ ӨВЧИН**

Нийт цочмог халдварт өвчний 439 тохиолдлоос:

- Сальмонеллэз 0 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 1 тохиолдлоор
- Хоолны хордлого 1 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 48 тохиолдлоор
- Халдварын гаралтай гастроэнтерит ба суулга 0 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 2 тохиолдлоор
- Хепатит В 1 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 3 тохиолдлоор
- Хепатит С 0 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 2 тохиолдлоор
- Ёлом 3 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 4 тохиолдлоор
- Хачигт рикеттиоз 0 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 1 тохиолдлоор
- Хачигт энцефалит 0 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 1 тохиолдлоор
- Гар хөл амны өвчин 13 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 2 тохиолдлоор
- Сүрьеэ 20 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 17 тохиолдлоор
- Улаан-Эсэргэнэ 0 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 3 тохиолдлоор
- Ковид-19 0 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 46 тохиолдлоор тус тус буурч
- Цусан суулга 30 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 3 тохиолдлоор
- Гахайн хавдар 2 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 2 тохиолдлоор
- Хачигт рикеттиоз 5 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 1 тохиолдлоор
- -Салхинцэцэг 364 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 274 тохиолдлоор тус тус өсч өмнөх оны үетэй адил тохиолдол байна.
- Өргөн дархлаажуулалт бүхий халдварт өвчнөөс халдварт саа, сахаруу, хөхүүл ханиад, татран, менингококкт халдварын өвчлөл бүртгэгдээгүй байна.


### Цочмог халдварт өвчин, бодит тоогоор




### ХАЛДВАРТ ӨВЧНИЙ ХАМ ШИНЖ, СЭЖИГТЭЙ ТОХИОЛДОЛ

- 2024 оны эхний 6 сарын байдлаар халдварт өвчний хам шинж, сэжигтэй, өвөрмөц 443 тохиолдол мэдээлэгджээ. Үүнээс цэврүүт тууралт 79.5 хувь (352), цочмог халууралт тууралтат 12.4 хувь (55), цочмог цусархаг тууралтат 6.8 хувь (30), цочмог усархаг 0.2 хувь (1), цочмог шарлалттай 0.5 хувь (2), гахай хавдар 0.5 хувь (2), хоолны хордлогот халдвар 0.2 хувь (1) тус тус бүртгэгдсэн байна.
- Нийт мэдээлэгдсэн хам шинжийн өвчлөл /бодит тоогоор/

### Халдварт өвчний хам шинж, сэжигтэй өвөрмөц тохиолдол, харьяалалаараа




### Халдварт өвчний хам шинж, сэжигтэй нийт тохиолдол, бүртгэгдсэн долоо хоногоор




Тохиолдлын нэр	2023 он		2024 он	
	бодит тоо	дүнд эзлэх хувь	бодит тоо	дүнд эзлэх хувь
Халууралт тууралт	56	23.6	55	12.4
Цэврүүт тууралт	96	40.5	352	79.5
Цусархаг суулгалт	24	10.1	30	6.8
Усархаг суулгалт	6	2.5	1	0.2
Цочмог шарлалт	6	2.5	2	0.5
Гахайн хавдар	0	0.0	2	0.5
Хоолны хордлогот халдвар	49	20.7	1	0.2
Нийт	237	100.0	443	100.0

## ТОМУУ, ТОМУУ ТӨСТ ӨВЧИН


2024 оны эхний 6 сарын байдлаар аймгийн хэмжээнд ТТӨ-ий 20086 тохиолдол бүртгэгдсэн нь 10000 хүн амд 1467.4 болсон байна. Харин өнгөрсөн оны мөн үед 16538 тохиолдол бүртгэгдэж 10000 хүн амд 1201.6 болсон байна.



### Томуу, томуу төст өвчин (насны бүлэг, хувиар)



### АЗЦХХ-ын хэвтэлт (насны бүлэг, хувиар)



## БЭЛГИЙН ЗАМЫН ХАЛДВАРТ ӨВЧИН


Нийт халдварт өвчний дотор БЗХӨ-ний эзлэх хувь 40.7% (301) тохиолдол байгаа ба өнгөрсөн оны мөн үед 61.3% (456) тохиолдол бүртгэгдсэнээс:

- Тэмбүү 84 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 1 тохиолдлоор
- Трихомониаз 26 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 7 тохиолдлоор тус тус өсч
- Гонококкт халдвар 191 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 163 тохиолдлоор өссөн байна.

### Бэлгийн замын халдварт өвчин, 2024 оны эхний 6 сарын байдлаар



БЗХӨ насны бүлгээр, 2024 оны эхний 6 сараар



БЗХӨ боловсролын түвшингээр, 2024 оны эхний 6 сараар



## **ЗӨВЛӨМЖ: НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ХАЛДВАРТ ӨВЧНИЙ АСУУДАЛ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН М.ЧАГЦАЛНЯМ СҮРЬЕЭ ӨВЧИН**

Нийт халдварт өвчний дотор Сүрьеэ өвчин 2.7% буюу 20 тохиолдол байгаа ба өнгөрсөн оны мөн үед 4.9% буюу 37 тохиолдол бүртгэгдсэн ба 17 тохиолдлоор буурсан байна. Сүрьеэ өвчний шалтгаант нас баралт хагас жилийн байдлаар 1 тохиолдол бүртгэгдсэн ба өнгөрсөн оны мөн үед 1 тохиолдол бүртгэгдсэн байна.

**Сүрьеэ өвчний эрт илрүүлэг:** 2024 оны хагас жилийн байдлаар эрт илрүүлэг үзлэгт 36848 иргэн буюу 38% хамрагдсан ба өнгөрсөн оны мөн үед 26.6% буюу 11.4%-иар өссөн эерэг үзүүлэлттэй байна. Эрт илрүүлэг үзлэгийн хамрагдалт хангалтгүй Баянзүрх (24.4%), Тариалан (22.2%), Түнэл (20.8%), Ханх (0%), Цагаан-Уул (7.7%), Цэцэрлэг (21.3%), Чандмань-Өндөр (14.4%), Эрдэнэбулган (19.9%) зэрэг сумын эрүүл мэндийн төвүүд аймгийн дунджаас доогуур үзүүлэлттэй байна.

**Сорьц тээвэрлэлт:** 2024 оны хагас байдлаар 118 удаагийн давтамжтай 206 сэжигтэй тохиолдлын цэрний сорьц тээвэрлэхэд 4 сүрьеэ өвчний тохиолдол бүртгэгдсэн байна. Сорьц тээвэрлэлт 21.4%-тай байна. Сүрьеэгийн шинэ тохиолдол Рэнчинлхүмбэ 2, Тариалан 1, Рашаант сум 1 тохиолдол тус тус бүртгэгдсэн байна.

Баянзүрх (8.3%), Бүрэнтогтох (16.7%), Жаргал (12.5%), Рашаант (8.3%), Тариалан (8.3%), Тосонцэнгэл (16.7%), Төмөрбулаг (8.3%), Улаан-Уул (8.3%), Ханх (8.3%), Шинэ-Идэр (8.3%) эрүүл мэндийн байгууллагуудын сорьц тээвэрлэлт аймгийн дунджаас (9.2%)-аас бага байна.

Эрдэнэбулган сумын эрүүл мэндийн төв 2024 он гарсаар огт сорьц тээвэрлэлт хийгээгүй байна.

### **ЦААШИД АНХААРАХ ЗӨВЛӨМЖ:**

1. Эрт илрүүлэг үзлэг аймгийн дунджаас доогуур байгаа байгууллагууд хамрагдалтын нэмэгдүүлэх чиглэлээр арга хэмжээ авч ажиллах
2. Эрүүл мэндийн сайдын А/38 дугаар тушаалын дагуу Тохиолдлын хяналтын бүртгэлийн дэвтрийг эмч бүр хөтөлж, сэжигтэй тохиолдлыг эрсдэлт бүлгийн хүн амын нэрсэнд оруулан үзлэг шинжилгээнд хамруулж оношийг батлах хүндрэлээс урьдчилан сэргийлэх
3. Сүрьеэгийн асуумжид үзлэгийн сэжигтэй тохиолдолд сорьц тээвэрлэх, сар бүр хоёр сорьцыг заавал тээвэрлэх
4. Батлагдсан тохиолдлын хавьтал судлалыг тухай бүр хийж, хавьтлын товлолын үзлэг, шинжилгээнд цаг тухай бүр хамруулах
5. Сорьц тээвэрлэлт хийж байгаа тохиолдолд хариу авах үйл явц дээр хяналттай ажиллах, хариуг гарсан эсэхийг баталгаажуулж мэдээлж байх

### **БЭЛГИЙН ЗАМААР ДАМЖИХ ХАЛДВАРТ ӨВЧИН**

Нийт халдварт өвчний дотор БЗХӨ-ний эзлэх хувь 40.6% буюу 301 тохиолдол байгаа ба өнгөрсөн оны мөн үед 61.4% буюу 457 тохиолдол бүртгэгдсэн ба өвчлөл 20.8%-иар буурсан үзүүлэлттэй байна:

Үүнд:

- Трихомониаз 26 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 7 тохиолдлоор өссөн
- Гонококкт халдвар 191 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 163 тохиолдлоор буурч
- Тэмбүү 84 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 1 тохиолдлоор тус тус буурсан үзүүлэлттэй байна.

### **БЗДХӨ-НЫ ЭРТ ИЛРҮҮЛЭГ:**

2024 оны хагас жилийн байдлаар 24865 иргэн буюу 29.1%-тай хамрагдсан ба өнгөрсөн оны мөн үед 20024 иргэн буюу 23.2% ба илрүүлэг үзлэг 5.9%-иар өссөн эерэг үзүүлэлттэй байна.

Эрт илрүүлэг үзлэгийн хамрагдалт хангалтгүй Түнэл (6.5%), Ханх (1.3%), Цагаан-Уул (11.3%), Цэцэрлэг (9.2%), Эрдэнэбулган (11.4%), Дэлгэрмөрөн (6.8%), Гурвангал (2.8%) зэрэг эрүүл мэндийн төвүүд аймгийн дунджаас доогуур үзүүлэлттэй байна.

### **ЦААШИД АНХААРАХ ЗӨВЛӨМЖ:**

1. Илэрсэн тэмбүү өвчнийг бүрэн эрүүлжүүлэх, тэдгээрийн хавьтал судлах ажлын чанарыг сайжруулах
2. Жирэмсэн эмэгтэйчүүдийг үзлэг шинжилгээнд товлолын дагуу бүрэн хамруулах
3. Иргэдэд чиглэсэн нэр хаяггүй, нууцлал хадгалсан зөвлөгөө үйлчилгээг бий болгох
4. Түр оршин суугч, явуулын ажил хийдэг, зорилтот бүлэгт чиглэсэн урьдчилан сэргийлэх идэвхтэй илрүүлэг үзлэг зохион байгуулах
5. Эрт илрүүлэг үзлэг аймгийн дунджаас доогуур байгаа байгууллагууд хамрагдалтын нэмэгдүүлэх чиглэлээр арга хэмжээ авч ажиллах

## **ДАРХЛААЖУУЛАЛТ**

Заавал хийх дархлаажуулалтад хамрагдвал зохих 17580 хүүхдээс 17054 хүүхэд буюу хамрагдалт 97%-тай байгаа ба өмнөх оны мөн үеэс 1.42%-иар өссөн эерэг үзүүлэлттэй байна. Заавал хийх дархлаажуулалтаас 308 хүүхэд хоцорсон байна.

Арбулаг (94.9%), Баянзүрх (91.5%), Жаргалант (94.3%), Рэнчинлхүмбэ (95.7%), Түнэл (96.4%), Ханх (94.1%), Цагааннуур (91.7%), Цагаан-Уул (96.6%), Далайн-Элбэрэлт (94.2%), Дэлгэрмөрөн (92.4%), Энэрэл (94.8%) эрүүл мэндийн байгууллагуудын хамралт аймгийн дундаж хамралт (97%)-иас бага байна.

## **ЦААШИД АНХААРАХ ЗӨВЛӨМЖ:**

1. 0-15 настай хүүхдэд заавал хийх дархлаажуулалтын хамрагдалтыг нэмэгдүүлэх чиглэлээр сар бүр нөхөн дархлаажуулах ажлыг зохион байгуулах.
2. Вакцин био бэлдмэлийг үйлдвэрлэгчийн зааврын дагуу зохих хэмд хадгалж, вакцины хүйтэн хэлхээний горимд тогтмол хяналт хийн, хэм хяналтын дэвтэрт өглөө орой бүр тэмдэглэл хөтлөх, нэмэлт цахилгааны эх үүсгэврийн бэлэн байдлыг хангах.
3. Шилжилт хөдөлгөөн эхэлж байгаатай холбогдуулан дархлаажуулалтын хамралтаас хоцорсон тохиолдолд өөрт аль ойрхон эрүүл мэндийн байгууллагад хандаж дархлаажуулалтад хамрагдах тухай мэдээллийг ард иргэдэд түгээх
4. Баяр наадмын амралт болон шилжилт хөдөлгөөн эхэлж байгаатай холбогдуулан дархлаажуулалтын хамралт буурдаг. Тиймээс ард иргэдэд товлолын дархлаажуулалтын хамралтыг нэмэгдүүлэх арга хэмжээг хэрэгжүүлж, үр дүнг тооцож ажиллах
5. Тайлан мэдээг сар бүрийн сүүлийн өдрөөр тасалж мэдээг цаг тухайд ирүүлэх.

## **ЗӨВЛӨМЖ: НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ТАРХВАР СУДЛАЛ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН Д.ӨЛЗИЙСАЙХАН**

Эхний хагас жилийн байдлаар 7 төрлийн халдварт өвчний хамшинж, сэжигтэй, өвөрмөц 443 тохиолдол мэдээлэгдсэн байна. Үүнээс цочмог цусархаг суулгалтат хамшинж 30(6,7%), цочмог халууралт, цэврүүт тууралтат хамшинж 352(79,4%), цочмог усархаг суулгалтат хамшинж 1(0.2%), хоолны хордлогот халдвар 1(0.2%), цочмог шарлалтат хамшинж 2(0.4%), гахайн хавдар 2(0,4%), цочмог халууралт тууралт 55(12,4%) тохиолдол тус тус мэдээлэгдсэн байна.

7 төрлийн 419 халдварт өвчний тохиолдол бүртгэгдэж 10 000 хүн амд 53.8 тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 10 000 хүн амд 0,2 тохиолдолоор бага байна. Аймгийн дундаж өвчлөл сүүлийн 5 жилийн дунджаар 10,000 хүн амд 118,8 тохиолдол байна. Нийт өвчлөлийн 44,7 % нь сум орон нутагт бүртгэгдсэн . 10,000 хүн ам дахь тохиолдлын тоогоор аймгийн дунджаас өндөр өвчлөл бүртгэгдсэн 5 сум байна.

Үүнд: Тосонцэнгэл 78.9, Цэцэрлэг 76.3, Чандмань-Өндөр 85.5, Эрдэнэбулган 57.8, Мөрөн 95,4 байна.

Салхинцэцэг, цусан суулга тус тус нэмэгдсэн байна. Салхинцэцэг нийт өвчлөлийн дотор 49,1%, нийт амьсгалын замын тууралтат халдварын дотор 98,2%-ийг эзэлж, бусад халдваруудтай харьцуулахад өндөр бүртгэгдсэн.

Томуу томуу төст өвчин 26 долоо хоногийн хугацаанд аймгийн хэмжээнд 10 000 хүн амд дунджаар 1467,4 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэтэй харьцуулахад 265,8 тохиолдолоор их байна. Аймгийн хэмжээнд 26 дугаар долоо хоногоос эхлэн өвчлөл нэмэгдэж 10000 хүн амд 74,4 тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх томуугийн улиралын мөн үетэй харьцуулахад 53,3 тохиолдолоор их байна.

## **ЦААШИД АНХААРАХ ЗӨВЛӨМЖ:**

1. Халдварт өвчний хам шинж сэжигтэй өвөрмөц тохиолдлын бүртгэл мэдээллийг сайжруулж, дэгдэлтийг босго үзүүлэлтийн дагуу яаралтай мэдээлж анхны арга хэмжээг авч ажиллах,
2. Нэмэлт амбулаторийг өвчлөлийн түвшин, нөхцөл байдалтай уялдуулан нэмэлтээр зохион байгуулах, төлөвлөх.
3. Эрүүл мэндийн байгууллагууд давтан хэвтэлтэнд хяналт тавих, халдварын сэргийлэлт, хяналтын арга хэмжээг эрчимжүүлэх.
4. Гэдэсний халдварт өвчин, цусан суулга, салхин цэцэг, томуу томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудад сургалт, сурталчилгаа, санамж, зөвлөгөө мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлж эрчимжүүлэх.

## **ЗӨВЛӨМЖ: НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ХООЛ ТЭЖЭЭЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН АСУУДАЛ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН П.ЛХАГВАСҮРЭН**

### **БАГА НАСНЫ ХҮҮХДИЙН ӨСӨЛТ ХӨГЖИЛТИЙН ЧИГЛЭЛЭЭР**

2024 оны хагас жилийн байдлаар 0-59 сартай давхардсан тоогоор нийт 30595 хүүхэд өсөлтийн хяналтад хамрагдсан ба өсөлтийн хяналт 87.4%-тай байна. Өсөлтийн хяналтад хамрагдсан хүүхдүүдээс өсөлтийн хоцрогдолтой 28 хүүхэд /0.01%/, туранхай 8 /0.01%/, тураалтай 19 /0.03%/, хүүхэд бүртгэгдсэн нь өмнөх оны үзүүлэлтээс өсөлтийн хоцрогдол 10 хүүхдээр, туранхай 8 хүүхдээр, тураал 6 хүүхдээр тус тус буурч, жингийн илүүдэлтэй хүүхдийн тоо 31-ээр, таргалалттай хүүхдийн тоо 13-аар тус тус нэмэгдсэн байгаагаас үзэхэд жил ирэх тусам жингийн илүүдэл, таргалалттай хүүхдийн тоо нэмэгдэх хандлагатай байна.

Мөн эхний 6 сарын байдлаар А амин дэм уусан 06-59 сартай 10180 хүүхэд буюу 90.5% нь, Д амин дэм уусан 0-59 сартай 17130 хүүхэд буюу 56%, ОНБТБ уусан 06-23 сартай 2215 хүүхэд буюу 18% нь тус тус амин дэм, бичил тэжээлийн бэлдмэл хэрэглэсэн байна. 2023 оны хагас жилтэй харьцуулахад А амин дэмийн хамралт 37.6%-иар өссөн бол ОНБТБ, Д амин дэмийн хамралт мөн оны үзүүлэлттэй ижил түвшинд байна.

## **ЦААШИД АНХААРАХ ЗӨВЛӨМЖ:**

1. Эрүүл мэндийн сайдын 2020 оны 490 дүгээр тушаалын дагуу амин дэм, бичил тэжээлийн бэлдмэлийн нөөцийг бүрдүүлж, хэрэглээг нэмэгдүүлэн ажиллах, хэрэглээг дэмжих зорилгоор ОНБТБ, А, Д амин дэмийн ач тус, хэрэглэх хэмжээ, хугацааны талаар мэдээлэл, сургалт зөвлөгөөг эцэг эхэд тасралтгүй өгч ажиллах.
2. ОНБТБ-ийн орлого, зарлага, хэрэглээг ОНБТБ-ийн хагас жилийн мэдээтэй тулгаж, үлдэгдлийг шахаж, хамралтын хувийг нэмэгдүүлж ажиллах.
3. Анхан шатны бүх эрүүл мэндийн байгууллагууд эрүүл мэндийн газрын даргын 2024 оны 509 дүгээр албан бичгээр хүргэгдсэн бага насны хүүхдийг чийрэгжүүлэх зуны сувиллыг үр дүнтэй, хүртээмжтэй хэлбэрээр зохион байгуулж, тайлан мэдээг заасан хугацаанд ирүүлэх.
4. Анхан шатны эрүүл мэндийн байгууллагууд 0-5 хүртэлх насны хүүхдийн өсөлт хөгжлийн хяналтыг товллолын дагуу сар бүр хийж, хооллолтын бэрхшээлийг эрт үед нь илрүүлж, насанд тохирсон хооллолтын зөвлөгөө үйлчилгээг чанартай хүргэж, бэрхшээлийг арилгах арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулах.
5. Эх хүүхдийн эрүүл мэндийн дэвтэрт сар бүрийн үзлэгийн тэмдэглэл болон өсөлт хөгжлийн муруйг тэмдэглэх, хэрхэн тэмдэглэх талаар эцэг эхэд зааж сургах.



ХЯНАСАН:  
ДҮГНЭЛТ ХИЙСЭН:

ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГА  
М.ҮҮРИЙНБАЯР  
ЭРҮҮЛ МЭНДИЙН МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ ХАРИУЦСАН  
МЭРГЭЖИЛТЭН П.БАЯРМАА